



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 16 өдөр

Дугаар А/179

Бөхт

Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-9.8 дах хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 1-ний өдрийн А/179 дугаар тушаал, Аймгийн Засаг Даргын 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн А/457 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч	Б.Мядагмаа	(Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч)
Гишүүд	Э.Сумъяа	(1 дүгээр багийн Засаг дарга)
	Д.Шинэбаяр	(2 дугаар багийн Засаг дарга)
	Б.Цэрэнням	(Бөхт таван эрдэнэ ХХК-ны малын их эмч)

2. Дархлаажуулалтын ажлыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Тархвар зүйч (Б.Мядагмаа)-д, тарилгын ажлыг үр дүнтэйгээр зохион байгуулж ажиллахыг Бөхт таван эрдэнэ ХХК-ны малын их эмч (Б.Цэрэнням)-д, Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад охин тугал, хурга, ишгийг бүрэн хамруулах, малчид, мал бүхий иргэдэд тов мэдээг хүргэн бэлэн байдлыг хангуулахыг багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ